



**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ**

2023 оны 03 сарын 22 өдөр

Дугаар A/120

Улаанбаатар хот

Аргачлал батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3 дахь заалт, Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3, 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсэг, Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн “Журам батлах тухай” 409 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн судалгааны үндсэн чиглэлийг тодорхойлох, санхүүжүүлэх” журмын 3.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн судалгааны үндсэн чиглэлд олгох санхүүжилтийн хэмжээг тооцох, хуваарилах аргачлал”-ыг хавсралт ёсоор баталсугай.
2. Төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн судалгааны үндсэн чиглэлд олгох санхүүжилтийн хэмжээг тооцох, хуваарилах ажлыг батлагдсан аргачлалын дагуу гүйцэтгэж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, инновацийн хөгжүүлэлт, хэрэгжүүлэлтийг зохицуулах газар /Д.Баттогтох/-т, Шинжлэх ухаан, технологийн сан /Д.Одгэрэл/-д тус тус үүрэг болгосугай.

САЙД  Л.ЭНХ-АМГАЛАН



ТӨРИЙН ӨМЧИТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН, ТӨВИЙН СУДАЛГААНЫ
ҮНДСЭН ЧИГЛЭЛД ОЛГОХ САНХҮҮЖИЛТИЙН ХЭМЖЭЭГ ТООЦОХ, ХУВААРИЛАХ
АРГАЧЛАЛ

Нэг. Зорилго

1.1. Төрийн захиргааны төв байгууллагаас санхүүждэг төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн судалгааны үндсэн чиглэлд олгох санхүүжилтийн хэмжээг тооцох, хуваарилахад энэхүү аргачлалыг баримтлана.

Хоёр. Төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн судалгааны үндсэн чиглэлийн санхүүжилтийн зардлын ангиллын итгэлцүүр тооцох

2.1. Засгийн газрын 2022 оны 409 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн судалгааны үндсэн чиглэлийг тодорхойлох, санхүүжүүлэх журам”-ын 3 дугаар зүйлийн 3.3. дахь хэсэгт заасны дагуу шинжлэх ухааны ангилалтай уялдуулан судалгааны үндсэн чиглэлийн санхүүжилтийн зардлыг дараах байдлаар тодорхойлно.

Судалгааны үндсэн чиглэлийн санхүүжилтийн
зардлын ангиллын итгэлцүүр

№	Зардлын ангилал	Байгалийн ухаан, Инженерчлэлийн ухаан, технологи	Анагаах ухаан, эрүүл мэнд, Хөдөө аж ахуйн шинжлэх ухаан	Хүмүүнлэг, нийгмийн шинжлэх ухаан
1.	1.Судалгаа, туршилт хийх, дээж шинжлүүлэх, урвалж бодис худалдан авах (3.3.1); 2.Мэргэжлийн хянан магадалгаа бүхий олон улсын эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл нийтлүүлэх, бодлогын зөвлөмж боловсруулах (3.3.2);	0.40	0.35	0.25
2.	1.Дотоод, гадаад томилолтоор ажиллуулах, социологийн болон хээрийн судалгаа (экспедиц) явуулах (3.3.7); 2.Суурин судалгааны төв, мониторингийн цэг, байнгын станц ажиллуулах (3.3.4); 3.Судалгаа, туршилт, малтлагын зориулалттай бага оврын техник, багаж, тоног төхөөрөмж болон компьютер, программ хангамж, тэдгээрийн сэлбэг хэрэгсэл	0.35	0.40	0.35

	худалдан авах, суурилуулах, засвар үйлчилгээ хийх (3.3.10); 4.Лабораторийн туршилт, шинжилгээ, баталгаажуулалт, магадлан итгэмжлэл, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах (3.3.8);			
3.	1.Оюуны өмч, зохиогчийн эрх болон аж үйлдвэрийн өмч бүртгүүлэх, мэдүүлэх, тусгай зөвшөөрөл авах (3.3.3); 2.Эрдэм шинжилгээний хурал, семинар, үзэсгэлэн зохион байгуулах, мэргэжлийн сэтгүүлийг хөгжүүлэх (3.3.5); 3.Архив, номын сангийн үйлчилгээний төлбөр (3.3.9); 4.Эх бэлтгэл, ном хэвлүүлэх, судалгааны сан хөмрөг бүрдүүлэх (3.3.6);	0.25	0.25	0.40

Гурав. Шинжлэх ухааны ангиллаас хамаарсан итгэлцүүр тооцох

3.1. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас гаргасан “Фраскатиин гарын авлага. Судалгаа, туршилт хөгжлийн асуулгад баримтлах жишиг стандарт”-ыг баримтлан шинжлэх ухааны ангиллаас хамаарсан итгэлцүүр c_i –г дараах байдлаар тодорхойлно.

Шинжлэх ухааны ангиллаас хамаарсан C_i итгэлцүүр

№	Судалгааны чиглэл		C_i итгэлцүүр
1	Шинжлэх ухааны ангиллаар	Байгалийн шинжлэх ухаан	0.40
2		Инженерийн ухаан, технологи	
3		Анагаах ухаан, эрүүл мэндийн шинжлэх ухаан	0.35
4		ХАА-н шинжлэх ухаан	
5		Нийгмийн шинжлэх ухаан	0.25
6		Хүмүүнлэгийн ухаан	

Дөрөв. Эрдэм шинжилгээний ажилтны тооноос хамаарсан итгэлцүүр μ_i тооцох

$$\mu_i = \frac{\text{ЭША}_i}{\sum_{j=1}^{28} \text{ЭША}_j} \quad (1)$$

ЭША_i – тухайн төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн эрдэм шинжилгээний ажилтны тоо;

$\sum_{j=1}^{28} \text{ЭША}_j$ – Засгийн газрын 299, 328 дугаар тогтоолоор байгуулагдсан төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн, төвүүдийн нийт эрдэм шинжилгээний ажилтны тоо.

Тав. Төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн төсвийн итгэлцүүр k_i тооцох

Дээрх 2 итгэлцүүрийг үржүүлж нормчилсоноор төрийн өмчит эрдэм шинжилгээний

хүрээлэн, төвийн төсвийн итгэлцүүр K_i -г дараах байдлаар тодорхойлно.

$$K_j = \frac{c_i \cdot \mu_i}{\sum_{j=1}^{28} c_j \cdot \mu_j} \quad (2)$$

Зургаа. Судалгааны үндсэн чиглэлийн санхүүжилтийг хуваарилах

Нийт төсвийг K_i төсвийн болон судалгааны үндсэн чиглэлийн санхүүжилтийн зардлын ангиллын d_i итгэлцүүрээр үржүүлж, төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн, төвүүдийн судалгааны үндсэн чиглэлийн санхүүжилтийг хуваарилна.

$$\text{Тухайн ЭШБ} - \text{ын үндсэн чиглэлийн санхүүжилт} = \sum_{i=1}^3 K_i \cdot \text{Нийт төсөв} \cdot d_i \quad (3)$$

Судалгааны үндсэн чиглэлийн тухайн оны нийт төсөв 3,000,000,000.00 (гурван тэрбум сая) төгрөг гэж үзье.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас гаргасан “Фраскатиин гарын авлага. Судалгаа, туршилт хөгжлийн асуулгад баримтлах жишиг стандарт”-д заасны дагуу Математик, тоон технологийн хүрээлэнгийн судалгааны үндсэн чиглэл нь шинжилгээний ангиллаар “Байгалийн шинжлэх ухаан”-д хамаарна. Иймд

Шинжлэх ухааны ангиллаас хамаарсан итгэлцүүр $c_i=0.40$

Засгийн газрын 299, 328 дугаар тогтоолоор байгуулагдсан 28 эрдэм шинжилгээний байгууллага, төвүүдэд нийт 1459 эрдэм шинжилгээний ажилтан. Шинжлэх ухааны академийн Математик, тоон технологийн хүрээлэнгийн 42 эрдэм шинжилгээний ажилтантай (1) томъёогоор эрдэм шинжилгээний ажилтны тооноос хамаарсан μ_i итгэлцүүрийг тооцвол:

$$\mu_i = \frac{\text{ЭША}_i}{\sum_{j=1}^{28} \text{ЭША}_j} = \frac{42}{1459} = 0.02879$$

Эрдэм шинжилгээний ажилтны тооноос хамаарсан μ_i итгэлцүүрийн утга 0.02879 болно.

Дээрх 2 итгэлцүүрийг үржүүлж нормчилсоноор төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн төсвийн итгэлцүүр K_i -г (2) томъёогоор тодорхойлбол:

$$K_i = \frac{c_i \cdot \mu_i}{\sum_{j=1}^{28} c_j \cdot \mu_j} = \frac{0.40 \cdot 0.02879}{0.36062} = \frac{0.01151}{0.36062} = 0.03193$$

Математик, тоон технологийн хүрээлэнгийн төсвийн K_i итгэлцүүрийн утга 0.03193 болно.

Нийт төсвийг K_i төсвийн болон судалгааны үндсэн чиглэлийн санхүүжилтийн зардлын ангиллын d_i итгэлцүүрээр үржүүлж, Математик, тоон технологийн хүрээлэнгийн судалгааны үндсэн чиглэлийн нийт санхүүжилтийг (3) томъёогоор тооцож хуваарилна.

$$\begin{aligned} \text{МТТХ} - \text{ийн нийт санхүүжилт} &= \\ &= 0.03193 \cdot 3,000,000 \text{ сая төг.} \cdot (0.40 + 0.35 + 0.25) = \\ &= 95,790.17 \text{ мянган төгрөг гэж тооцно.} \end{aligned}$$

Математик, тоон технологийн хүрээлэнгийн судалгааны үндсэн чиглэлийн санхүүжилтийн зардлын ангиллын итгэлцүүр d_i , түүнд харгалзах төсвийн хуваарилалт

№	Зардлын ангилал	Итгэлцүүр d_i	Төсөв, мян. төг.
1	1. Судалгаа, туршилт хийх, дээж шинжлүүлэх, урвалж бодис худалдан авах (3.3.1); 2. Мэргэжлийн хянан магадалгаа бүхий олон улсын эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл нийтлүүлэх, бодлогын зөвлөмж боловсруулах (3.3.2);	0.4	38,316.07
2	1. Дотоод, гадаад томилолтоор ажиллуулах, социологийн болон хээрийн судалгаа (экспедиц) явуулах (3.3.7); 2. Суурин судалгааны төв, мониторингийн цэг, байнгын станц ажиллуулах (3.3.4); 3. Судалгаа, туршилт, малтлагын зориулалттай бага оврын техник, багаж, тоног төхөөрөмж болон компьютер, программ хангамж, тэдгээрийн сэлбэг хэрэгсэл худалдан авах, суурилуулах, засвар үйлчилгээ хийх (3.3.10); 4. Лабораторийн туршилт, шинжилгээ, баталгаажуулалт, магадлан итгэмжлэл, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах (3.3.8);	0.35	33,526.56
3	1. Оюуны өмч, зохиогчийн эрх болон аж үйлдвэрийн өмч бүртгүүлэх, мэдүүлэх, тусгай зөвшөөрөл авах (3.3.3); 2. Эрдэм шинжилгээний хурал, семинар, үзэсгэлэн зохион байгуулах, мэргэжлийн сэтгүүлийг хөгжүүлэх (3.3.5); 3. Архив, номын сангийн үйлчилгээний төлбөр (3.3.9); 4. Эх бэлтгэл, ном хэвлүүлэх, судалгааны сан хөмрөг бүрдүүлэх (3.3.6);	0.25	23,947.54
ШУА-ийн МТТХ-ийн судалгааны үндсэн чиглэлийн санхүүжилт, мян. төг.:			95,790.17